

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2013 оны 09 дүгээр сарын 06

Тендер шалгаруулалтын нэр: **“Булган хангай” хорооллыг дулаан, цахилгааны эрчим хүчээр хангах /Архангай/ ажлын зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах.**

Тендер шалгаруулалтын дугаар: **ХААГ-А-2013/XVIII-08**

Худалдан авах ажиллагааны газар нь эрх бүхий тендерт оролцогчдод **“Булган хангай” хорооллыг дулаан, цахилгааны эрчим хүчээр хангах /Архангай/ ажлын зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажил**-ыг гүйцэтгэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэл бүрийг нь **200,000 (хоёр зуун мянга)** төгрөгийг тушаан худалдан авч болно.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **45** хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 3 жилийн борлуулалтын орлогын аль нэг жил нь санал болгож буй үнийн дүнгийн 30%-с доошгүй байна.

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Санал болгож буй үнийн дүнгийн 30 хувиас багагүй байна.

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 3 жил буюу 2010, 2011, 2012 он.

Сүүлийн 3 жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: Сүүлийн 3 жилийн аль нэг жилд санал болгож буй үнийн дүнгийн 20 хувиас багагүй ижил төстэй ажил гүйцэтгэсэн байна.

Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх: **Тийм**

Зураг төсөл боловсруулах байгууллага нь:

1.3.1: Дулааны шугам гол сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн ажлын зураг,

1.3.3: Цахилгаан дамжуулах гол шугам, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн ажлын зураг /35 кВ хүртэл/ боловсруулах тусгай зөвшөөрөлтэй байх.

Барилга угсралтын ажил гүйцэтгэх байгууллага нь:

03.3.1: 115-250°C температуртай, 0.7-16.0кгх/см² даралттай зуухны угсралт, засвар,

03.5.1: 115-250°C температуртай, 0.7-16.0кгх/см² даралттай дулааны шугам хоолой, ЦТП-ны угсралт, засвар,

03.2.3: 04-35 кВ-ын цахилгаан дамжуулах шугам, дэд станцын угсралт засвар ажил үйлчилгээ гүйцэтгэх тусгай зөвшөөрөлтэй байна.

Тендерийн хамт **18,000,000 (арван найман сая)** төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг **2013 оны 10 дугаар сарын 07-ний өдрийн 11:00 цагаас өмнө** доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2013 оны 10 дугаар сарын 07-ний өдрийн 11 цаг 30 минутад** нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх **эрхгүй**.

Монгол Улсын гарал үүсэлтэй бараанд давуу эрхийн зөрүү **тооцохгүй**.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Их тойруу 80/1.
Нэг цэгийн үйлчилгээ. Утас: 70125060, 70111090.
www.e-tender.mn, www.e-procurement.mn.